



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 16 өдөр

Дугаар Б/43.

Ховд

М.Баатарыг томилох тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар тогтоолын 1 дэх заалтууд, Мянгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь Авлигатай тэмцэх газрын 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 05/13895 тоот албан бичгээр хянагдаж ирсэн Мөнхбаярын Баатарыг 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн Мянгад сумын Засаг даргаар томилсугай.

2. М.Баатарт Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1052207 төгрөг / Нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон /-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр бодож олгохыг Мянгад сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /Э.Номин/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг М.Баатарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/43 Ch

02 3996